



МОНГОЛ УЛС
ТӨВ АЙМГИЙН ЗУУНМОД СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 04 сарын 07 өдөр

Дугаар 4/53

Зуунмод

Газар эзэмшүүлэх дуудлага худалдаа
зохион байгуулах тухай

Монгол улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2, Газар өмчлөх тухай хуулийн 5.1.6.2, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Газар эзэмшүүлэх дуудлага худалдаа явуулах журам”, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 01 дүгээр сарын 12-ны 04 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын 2017 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу дуудлага худалдаа явуулах журмаар эзэмшүүлэх газрын байршил болон дуудлага худалдаа явуулахад тавигдах шаардлагыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2. Тогтоосон байршлуудад газар эзэмшүүлэх эрхийн цахимын дуудлага худалдаа зохион байгуулах бэлтгэл ажлын зардал, анхны үнийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3. Газар эзэмшүүлэх эрхийн цахим дуудлага худалдааг товлосон өдөр, баталсан анхны үнээс эхлэн зохих журмын дагуу зохион байгуулахыг Тамгын газрын дарга /Б.Баярсайхан/, газрын даамал /Р.Жавзандолгор, Т.Пүрэвдулам/, байгаль орчны хяналтын улсын байцаагч /Ч.Уранчимэг/ нарт үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамжийн биелэлтэнд хяналт тавьж 2017 оны 05 дугаар сарын 11-ны өдөр дуудлага худалдаа зохион байгуулахыг Засаг даргын орлогч /Г.Гантөгс/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.МӨНХБАДРАЛ

0500177

My.doc: Zahiramj-2017/01/

Сумын Засаг даргын 2017 оны 04 дүгээр
сарын 07-ны өдрийн 4/53 дугаар
захирамжийн 1 дүгээр хавсралт

**ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ ДУУДЛАГА ХУДАЛДАА ЯВУУЛАХАД
ТАВИГДАХ ШААРДЛАГА**

Зуунмод сумын Номт /1 дүгээр/ багт газар эзэмшүүлэх дуудлага худалдааг зохион байгуулна.

1. Номт /1 дүгээр/ багт газар эзэмшүүлэх.

№	Газрын байршил	Талбай хэмжээ	Зориулалт	Хугацаа /Жил/
1	Цэлмэг хотхон баруун хойд хэсэгт	0.36 га 3600 м ²	Амины орон сууц	15

Дуудлага худалдаанд оролцох хүсэлтэй иргэн, ААН, байгууллага 2017 оны 05 дугаар сарын 08-ны өдрөөс 10-ны өдрүүдэд 09:00-12:00, 13:00-18:00 цагийн хооронд Зуунмод Хотын Тамгын газарт бүртгүүлэхдээ доорх материалыг бүрдүүлж битүүмжилсэн хайрцагт хийнэ.

- Газрын дуудлага худалдаанд оролцох хүсэлт
- Иргэний үнэмлэхний хуулбар, ААНБ-бол тусгай зөвшөөрөл
- Тухайн газрын анхны үнийн 10%-ийн дэнчинг байршуулах/100142255408 тоот дансанд/
- Дуудлага худалдаанд оролцогчийн хураамж /5000 төгрөг/, ААНБ/10000/ төгрөгийн баримт
- Тэмдэгтийн хураамж /12500 төгрөгийг 142200941 тоот дансанд/

Газрын дуудлага худалдаагаар газар авсан иргэн, ААН, байгууллагатай газар эзэмших гэрээнд доорхи нөхцөлүүдийг тусган гэрээ хийнэ.Үүнд:

- Барилгыг өнгө үзэмж сайтай стандартын шаардлага хангасан арга зүйгээр орчин үеийн шийдэлтэй зургийг мэргэжлийн байгууллагаар хийлгэнэ. /Зурагт орчны тохижилтын зургийг хамт хийлгэж түүний дагуу тохижуулна/
- Техникийн нөхцлүүд болон мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг хийлгүүлнэ.
- Дуудлага худалдааг 2017 оны 05 дугаар сарын 11-ны өдөр эхэлнэ.

Холбоо барих утас:Газрын даамал- 70273030, Байгаль орчны хяналтын улсын байцаагч- 70273514

**ЗУУНМОД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗАР**

Сумын Засаг даргын 2017 оны 04 дүгээр
сарын 03 өдрийн 453 дугаар
захиралжийн 2 дугаар хавсралт

**ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ ЭРХИЙН ДУУДЛАГА ХУДАЛДАА
ЗОХИОН БАЙГУУЛАХ БЭЛТГЭЛ АЖЛЫН ЗАРДАЛ, ДУУДАХ АНХНЫ ҮНЭ**

№	Байршил	Газрын хэмжээ	Зориулалт	Газрын суурь үнэ	Дэд бүтцийн зардал	Дуудлага худалдаа дуудах анхны үнэ нийт
1	Цэлмэг хотхон баруун хойд хэсэгт	300м ²	Амины орон сууц	960000	7490000	8450000

ЗУУНМОД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗАР